

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТЭМДЭГЛЭЛ, ПРОТОКОЛ

2019 оны 04-р сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6 болон Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын Зар Хүргэх Журмын 3.8 болон 3.9-т тус тус заасныг удирдлага болгон ДСЦТС ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын дараах тэмдэглэл, протоколыг үйлдэн, шийдвэрийг гаргав. Үүнд:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал энэ өдрийн 11 цагт хуралдах ёстой байсан боловч Хасвуу ХХК-ийн төлөөлөл болон Иргэн С.Нэргүй хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаа ирэх боломжгүй болсон болохыг тэмдэглэсүгэй. /Хувьцаа эзэмшигчдийн хураангуй судалгааг хавсаргав./
2. Хойшлогдсон хурлын товыг 2019.05.01-ний өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Хасвуу Плаза" байрны хурлын танхимд хийхээр тогтоон хурал болох газар, тов цагийг хавсралт ёсоор баталсугай.
3. Хурал хойшлогдсон талаарх мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хөрөнгийн биржид 2019.04.15-ны дотор мэдэгдэх, энэхүү мэдэгдэлтэй холбоотой бүхий л шаардлагатай үйлдлийг Компанийг төлөөлөн хийх эрх, үүргийг Хуульч М.Баярманлад үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшлогдсон зарыг 2019.04.24-ний өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэхийг Хуульч.М.Баярманлад үүрэг болгосугай.


ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА:

ГИШҮҮД:

ГИШҮҮН:

ГИШҮҮН:

М.Баярманлад



Л.БАЛГАН

Ц.БАЯРБААТАР

Э.ДОЛГОРСҮРЭН

М.БАЯРМАНЛА



“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Хаяг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо “Хасвуу Плаза”-гийн хурлын танхимд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2019 оны 3-р сарын 21-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал: Хурлаар хэлэлцэх асуудал: Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах, (ii) Компанийн ТУЗ-өөс баталсан 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, (iii) Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах, (iv) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, (v) Компанийн ТУЗ-ийн 2019-2020 оны цалин урамшуулал болон зардлыг батлах, (vi) Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах, энгийн хувьцаа нэмж гаргах эсэх асуудлыг хэлэлцэн батлах, (vii) Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах, энгийн хувьцаа нэмж гаргах шийдвэрийг гаргасан тохиолдолд Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 5 дугаар сарын 3-ны өдрийн 11 цаг хүртэл ажлын цагаар “Хасвуу Плаза”-гийн хурлын танхимд танилцаж болно.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс

Утас: 11-318998

Цахим шуудан: kholboos@yahoo.com